

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 11 сарын 07
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201906667

“Монголросцветмет” ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Бор-Өндөр УБҮ-ийн тээрмийн 630кВт синхрон хөдөлгүүрийн сэргээлтийн блок (ТВ-300 дүйцэхүйц) 3 иж бүрдэл шинээр угсрах ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичигтэй танилцана уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000.00** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: *тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй*

Аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2017, 2018 он

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт, өртөг: ирүүлнэ

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: шаардлагатай. (цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт тохируулгын ажил эрхлэх)

Тендерийн хамт **1 650 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 12-р сарын 09-ны өдрийн 15:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба тендерийг **2019 оны 12-р сарын 09-ны өдрийн 15:05 цагт** цахимаар нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **эрхтэй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“Монголросцветмет” ТӨҮГ, УБ,БЗД, Энхтайвны өргөн чөлөө-98

(өрөөний дугаар №305)

утас/факс:450060+138, 243, факс: 458380